

## 9

## БАНК, МӨНГӨ-ЗЭЭЛИЙН ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДЛУУД

### П.Оюунбилэг

Монгол Улсад 1924 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан анхны банк үйл ажиллагаагаа явуулж эхэлснээр банкны систем үүсч, 1990-ээд он хүртэл банкны нэг системтэй байсан. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн банкны бүхий л үйл ажиллагаа нь урьдчилан төлөвлөгдсөн, хэнд зээл олгох, энэ зээл хэзээ яаж төлөгдөх, хэрэв төлөгдөхгүй бол хэн алдагдал хүлээх нь бүгд тодорхой байдаг байв. Иймд эрсдэл гэдэг ойлголт аль ч шатанд байдаггүй байв. Мөн жирийн иргэд зээл авах боломжгүй, тэд банкыг мөнгө хадгалдаг газар гэж л ойлгодог байсан гэхэд хилсдэхгүй.

1990-ээд оны эхээр улс оронд өөрчлөлт шинэчлэлийн уур амьсгал бий болж, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих болсноор санхүүгийн системийн хөгжилд шинэ үе эхэлж, энэ утгаараа банкны үйл ажиллагаанд ч шинэчлэл хийгдэх зайлшгүй шаардлага урган гарсан.

1991 оны 5 сард Улсын бага хурлаар Банкны хуулийг баталсан нь банкны үйл ажиллагааны эрх зүйн шинэ үндсийг тодорхойлсон юм. Энэ үеэс эхлэн Монгол орон дэлхий нийтийн жишгийн дагуу банкны нэг шатлалтай системээс хоёр шатлалтай системд жинхэнэ утгаараа шилжиж эхлэх нөхцөл бүрдсэн. 1996 онд Төв банкны болон банкны хуулийг Улсын Их Хурал шинэчлэн баталсан. Энэ нь Төв болон Арилжааны банкуудын эрх үүргийг улам бүр тодотгож өгсөн.

Монгол Улсын Төв банк нь Монгол банк юм. Төв банк /Монгол Банк/-ны тухай хуульд зааснаар Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны найдвартай ажиллагааг бүрдүүлэх замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Монгол банк нь банк хоорондын төлбөр тооцоог хийх, Засгийн газрын санхүүгийн зуучлагч, арилжааны банкуудын үйл ажиллагаанд хяналт тавих үүргүүдийг гүйцэтгэхээс гадна *эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх үүрэгтэй.*

1990-ээд оны эхээр банкны хууль батлагдаагүй байхад арилжааны хэд хэдэн банк байгуулагдаж, тэдгээр нь харилцагчийг өөртөө татах зорилгодоо хэт хөтлөгдөн, зээлийг их хэмжээгээр, хяналтгүйгээр, судалгаа шинжилгээгүйгээр уралдан олгож байсны улмаас зээлийн өрийн үлдэгдэл нийт мөнгөний хэмжээнээс 1990 онд 45.6%, 1991 онд 29.6%, 1992

онд 46.5% тус тус давсан явдал байв.

Төв банк клирингийн өмнөх тооцооны зээлийг дээрхи алдааг залруулах үүднээс арилжааны банкуудад олгож эхэлсэн нь Монгол банкны мөнгөний бодлогын хэрэгслийн анхны эхлэл болсон. Энэ зээл нь арилжааны банкуудыг санхүү төлбөрийн чадварын хүндрэлээс түр зуурын хугацаанд гаргах зориулалттай байсан хэдий ч арилжааны банкуудын хүссэн хэмжээгээр олгож, тэдгээр нь зээлийн эх үүсвэр болгон ашиглаж байснаас мөнгөний нийлүүлэлт өсч, инфляцийн түвшин нэмэгдэхэд нөлөөлсөн. Үүний тод жишээ гэвэл нийт мөнгө 1991 онд 76%, 1992 онд 31.6% өсч инфляци 1992 онд 325%, 1993 онд 183% хүртэл өссөн явдал юм.

Монгол банк 1991 оноос банкуудын заавал байлгах нөөцийн шаардлага тавьж эхэлснээр тэдгээр нь нөөцдөө анхаарлаа хандуулах болсон, 1992 онд клирингийн тооцоо (банк хоорондын харилцан суутгах) нэвтэрснээр банк хоорондын эх үүсвэрийн урсгалыг хянах бололцоотой болсон, мөн энэ үеэс тодорхой нөхцөл, шаардлагыг хангасан арилжааны банкуудад эх үүсвэрийн, дахин санхүүжилтын, хямдруулалтын зээлүүдийг олгож, үүгээр дамжуулан хүүгийн болон бусад зохицуулалтын бодлого явуулах нөхцлийг бүрдүүлсэн, 1993 оны сүүлчээс эхлэн эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт, нөөц мөнгөний хэмжээг зохицуулах, арилжааны банкуудын илүүдэл нөөцийг шууд бус аргаар удирдах зорилгоор Төв банкны үнэт цаас гаргах болсон зэргээр Монгол банкнаас мөнгөний бодлогын шууд ба шууд бус арга хэрэгслүүдийг уялдаа холбоотойгоор авч хэрэгжүүлж байгаа нь зохих үр дүнгээ өгч байна.

Монгол банкны тайлан тэнцэл  
(сая төгрөгөөр)

Хүснэгт №1

|                                     | 1996 он | 1997 он  | 1998 он  | 1999 он  |
|-------------------------------------|---------|----------|----------|----------|
| <b>Актив</b>                        |         |          |          |          |
| Касс                                | 30.2    | 125.2    | 259.9    | 12.0     |
| Үнэт металл                         | 3319.4  | 10015.2  | 4034.3   | 5851.6   |
| Гадвад актив                        | 38080.9 | 83111.8  | 139205.2 | 261967.4 |
| Үнэт цаас                           | 10740.7 | 11201.8  | 17689.7  | 21023.6  |
| ТБҮЦ-ны борлогдоогүй хэсэг          | 0.0     | 1581.3   | 47.8     | 0.0      |
| ЗГ-аас авах авлага                  | 19760.0 | 10300.3  | 12311.6  | 6560.2   |
| Арилжааны банкуудад олгосон зээл    | 1186.7  | 2414.4   | 5079.6   | 7130.1   |
| Банкны бус байгуулагад олгосон зээл | 3820.8  | 3177.5   | 8082.0   | 4894.1   |
| Бусад актив                         | 2015.2  | 5557.4   | 27318.1  | 20939.4  |
| Нийт актив                          | 80816.1 | 127584.9 | 214028.1 | 328378.4 |
| <b>Пассив</b>                       |         |          |          |          |
| Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө      | 31944.4 | 46.2     | 55702.3  | 98160.4  |
| ТБ-ны үнэт цаас                     | 0.0     | 17268.8  | 10615.1  | 22726.4  |
| Гадаад пассив                       | 27604.4 | 30083.7  | 69900.8  | 122186.2 |
| ЗГ-ын хадгаламж                     | 5402.5  | 6355.7   | 2623.1   | 5168.9   |
| Арилжааны банкуудын нөөц            | 3544.3  | 5041.1   | 11748.1  | 21982.5  |
| Банк бус нэгжийн хөрөнгө            | 0.0     | 1299.5   | 737.9    | 198.3    |
| Бусад пассив                        | 1688.0  | 787.4    | 26546.5  | 17387.1  |
| Өөрийн хөрөнгө                      | 10632.5 | 20556.9  | 36154.4  | 40568.5  |
| Нийт пассив ба өөрийн хөрөнгө       | 80816.1 | 127584.9 | 214028.1 | 328378.4 |

Хүснэгт №1- ээс харахад:

- арилжааны банкуудад олгосон зээл жилд дунджаар 30 орчим хувь өсч байгаа нь Төв банкны мөнгөний нийлүүлэлтийг удирдах нэг арга хэрэгсэл болж байна;

- арилжааны банкуудын нөөц ч тогтмол өсч байна. Арилжааны банкуудын бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тодорхой хувьтай тэнцүү хэмжээний нөөцийг заавал байлгах нөөцөд байршуулан, Монгол банкны харилцахад төвлөрүүлсэн хэсэгт нь хүү төлж байгаа нь арилжааны банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой. 1999 онд арилжааны банкуудаас Монгол банкны харилцах дансанд төвлөрүүлсэн хөрөнгөд 504.7 сая төгрөгийн хүү төлж, заавал байлгах нөөцийн хэмжээг хангаагүй банкуудад 935.5 сая төгрөгийн торгууль ногдуулжээ;

- Төв банкны үнэт цаасны эрэлт сайн байгааг тайлан тэнцлээс харж болох ба ТБҮЦ-ны хүүгээр дамжуулан Монголбанк хүүгийн нэгдсэн бодлого явуулж байна. ТБҮЦ-ны хүүг инфляцийн түвшингээс шууд хамааралтайгаар тогтоон банкуудын зээл, хадгаламжийн хүүд нөлөөлөх бодлого баримталж байна. 1998 онд ТБҮЦ-ны хүү жилийн 28.7% байсан бол 1999 онд 15.9% болж буурсан ч арилжааны банкуудын зээл, хадгаламжийн хүүний түвшинд дорвитой өөрчлөлт орохгүй байгаа нь арилжааны банкуудын өмнөх алдагдлаа нөхөх сэтгэлгээтэй холбоотой байж болох юм;

Монгол банкнаас мөнгөний хатуу бодлого явуулж, тодорхой арга хэмжээнүүд авч байгаа нь шилжилтийн жилүүдийн эхэнд 320 хувь байсан инфляци 10 орчим хувь хүртэл багасахад зохих нөлөө үзүүлсэн.

Төв банк мөнгөний бодлогоо арилжааны банкуудаар дамжуулан хэрэгжүүлдэг.

Банкны тухай хуульд зааснаар манай арилжааны банкууд дүрмийн сангийн өмчлөлөөр төрийн, хувийн болон холимог, үүсгэн байгуулагдсан хэлбэрээр хязгаарлагдмал хариуцлагатай, хувьцаат; банкны үйл ажиллагаа явуулах хэлбэрээр нийтлэг ба төрөлжсөн байж болно. Энэ заалтын дагуу манайд төрийн өмчит 1, төрийн өмчийн оролцоотой 5, хувийн 6 арилжааны банк байна.

Банкуудын 1996 - 2000 онуудын нэгдсэн тэнцлийг (Хүснэгт №2) шинжилж үзвэл:

- 1996 оноос хойш арилжааны банкны активын бүтцэд өөрчлөлт гарч эхэлсэн нь Монгол банкны үнэт цаас, Засгийн газрын бондыг ихээр худалдан авах болсон, банк хоорондын тооцоог клирингийн системд оруулж, бэлэн байгаа хөрөнгөд багтааж төлбөр гүйцэтгэж эхэлсэн зэрэгтэй холбоотой юм.

- Монгол банкнаас арилжааны банкуудад тавьж байсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдэд өөрчлөлт гарч, зээлийг депозитод харьцуулсан харьцаа 100-гаас бага байх гэсэн үзүүлэлтийг хасаж, түргэн борлогдох активыг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүнд харьцуулж төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг тооцох болсон ба энэ харьцааг 18 хувиас доошгүй түвшинээр тогтоосноор банкууд нөөцдөө анхаарлаа хандуулж түүнийг нэмэгдүүлэхийг эрмэлзэх болсон. Банкны нөөцийн хэмжээ тогтмол өсч байна.

- Нэгдсэн тайлангийн 1999.12.31-ний байдлаар Төв банкны үнэт цаас, Засгийн газрын бондод байршуулсан хөрөнгө нийлээд 29 хувьд хүрчээ. Энэ нь нэг талаас арилжааны банкууд нь Засгийн газрын болон Төв банкны явуулж буй мөнгөний бодлогыг дэмжиж, орлого авчрах найдвартай активт хөрөнгө байршуулахыг сонирхох болсныг харуулах боловч нөгөө талаас аж ахуйн нэгжүүдэд олгогдох зээлийн хэмжээ буурах, үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дамжуулан дэмжихэд арилжааны банкуудын сонирхол буурах болсныг харуулж байна.

Банкуудын нэгдсэн тэнцэл  
(сая төгрөгөөр)

Хүснэгт №2

|                                      | 1996            | 1997            | 1998            | 1999            | 2000            |
|--------------------------------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|
| Банкны нөөц                          | 6851.1          | 13456.7         | 17920.5         | 24167.2         | 31996.4         |
| ТБ-ны үнэт цаас                      |                 | 19056           | 11697           | 21203.9         | 22846.7         |
| Гадаад актив                         | 43253.9         | 66415.6         | 26115.7         | 41710.6         | 53313           |
| ЗГ-аас авах авлага                   | 12534.7         | 35450.8         | 38328.4         | 39268.7         | 40059.5         |
| ЗГ-ын үнэт цаас                      | 3893.2          | 34777.7         | 35789.8         | 38121.1         | 40006.5         |
| Үнэт цаас                            | 259.4           | 702.9           | 1115.7          | 2233.1          | 177.1           |
| ААН-ээс авах авлага                  | 68824.7         | 51515.7         | 86328           | 78248.5         | 67880.7         |
| ЗТУБАХС                              | -20306.2        | -11747.3        | -26510.3        | -36756.8        | -13404.8        |
| Бусад банкнаас авар авлага           | 3318.3          | 2761.9          | 3568.7          | 3859            | 2479.6          |
| Өмчлөх, бусад ҮХХ                    | 4896.6          | 3858.1          | 4553.7          | 5043.5          | 1176.6          |
| ӨБҮХХ-ийн болз. эрсдэлийн сан        | -0.2            | -0.2            | -595.3          | -2583.8         | -2766.1         |
| Үндсэн хөрөнгө                       | 11892.7         | 11397.3         | 12913.8         | 15868.3         | 15832.5         |
| Үнэт металл                          | 12.5            | 15.2            | 16.9            | 20.8            | 25              |
| Бусад актив                          | 8429.2          | 3397.8          | 4112.5          | 7909.9          | 3309.5          |
| <b>Нийт актив</b>                    | <b>137967.1</b> | <b>196279.7</b> | <b>179565.8</b> | <b>200193.0</b> | <b>225692.1</b> |
| <b>Пассив</b>                        |                 |                 |                 |                 |                 |
| Харилцах                             | 40519.8         | 61827.8         | 51495.1         | 62907.5         | 65223.1         |
| Хадгаламж                            | 45917.8         | 58469.4         | 59308.6         | 69978.1         | 92686.1         |
| Мөнгөний захын хэрэгсэлүүд           | 287.4           | 28.6            | 26              | 24.3            |                 |
| Тусгай хадгаламж                     | 13639.1         | 6430            | 6938            | 3604.2          | 2145.6          |
| МБ ба бусад банкинд өгөх өглөг       | 8868.8          | 3691.6          | 7212.6          | 5772.9          | 2443.7          |
| Гадаад пассив                        | 8620            | 12246.3         | 19892.5         | 9794.2          | 5866.2          |
| ЗГ-ын хадгаламж                      | 22587.7         | 33258.4         | 20081.1         | 24125.8         | 24607.1         |
| Бусад пассив                         | 11064.5         | 3557.4          | 7551.2          | 19420.3         | 2772.6          |
| Өөрийн хөрөнгө                       | 13538.1         | 16770           | 7060.3          | 19112.6         | 29947.5         |
| <b>Нийт пассив ба өөрийн хөрөнгө</b> | <b>137967.1</b> | <b>196279.7</b> | <b>179565.8</b> | <b>200193.0</b> | <b>225692.1</b> |

- Нийт пассивтай харьцуулахад өөрийн хөрөнгө өсч байгаа нь пассивын чанарт сайн нөлөө үзүүлж байна.

Арилжааны банкуудын төлбөрийн чадварыг доройтуулахгүй байх үндэс нь өөрийн хөрөнгийг тогтмол нэмэгдүүлж байх явдал юм.

Өнгөрсөн туршлагаас дүгнэлт хийхэд Төв банкны хяналт сул байснаас хэд хэдэн банкуудын төлбөрийн чадвар эрс суларч, санхүүгийн байдал муудаж байгааг цаг хугацаанд нь соргог мэдэрч, шийдвэрлэх арга хэмжээ авч чадаагүй цаг алдсанаас эдийн засгийн хохирлыг нэмэгдүүлэхэд хүргэсэн.

Төв банкнаас арилжааны банкуудыг хянах олон аргууд байдгийн нэг чухал бөгөөд тогтмол хяналтын арга нь банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг мөрдүүлж хянах арга юм. Одоогийн байдлаар Төв банкнаас хэд хэдэн шалгуур үзүүлэлтүүдийг мөрдүүлж байна. Үүнээс өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаануудыг сар, улирал, жилийн тайлан тэнцэлдээ үндэслэн үнэн зөв тооцож байх явдал нь тухайн банкны цаашдын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг тооцох, сэргийлэх ач холбогдолтой.

Манай арилжааны банкуудын хамгийн том эрсдэл нь зээлийн эрсдэл юм. Арилжааны банкууд үүссэн цагаас зээлийн удирдлага зохион байгуулалт хангалтгүй, зээлийн бодлого чанаргүй, дотоод хяналтын систем зохистой ажиллаагүй зэргээс үүдэн 1994-1999 онуудын хооронд 15 арилжааны банк дампуурчээ. Эдгээр банкуудын дампуурлын нэг том шалтгаан нь муу зээл юм.

1996-2000 онуудын арилжааны банкуудын зээлийн өрийн үлдэгдэлд чанарын ангиллаар судалгаа хийж үзэхэд:

Арилжааны банкуудын зээлийн чанарын ангилал  
(сая төгрөг)

Хүснэгт №3

|                       | 1996 он  | 1997 он  | 1998 он  | 1999 он  | 2000 он  |
|-----------------------|----------|----------|----------|----------|----------|
| Хугацаа хэтэрсэн зээл | 66 824.7 | 51 515.7 | 86 328.1 | 78 248.5 | 67 659.9 |
| Чанаргүй зээл         | 32 947.9 | 14 457.6 | 32 638.8 | 42 106.7 | 18 072.8 |
| Хугацаа хэтэрсэн      | 8 057.7  | 4 553.9  | 6 051.9  | 2 925.6  | 1 281.8  |
| Хэвийн бус            | 3 476.6  | 2 078.1  | 4 767.2  | 3 010.7  | 1 426.9  |
| Эргэлзээтэй           | 7 008.2  | 3 129.3  | 8 739.2  | 4 437.6  | 750.3    |
| Муу                   | 14 405.3 | 4 696.1  | 13 080.5 | 31 732.7 | 613.8    |

Нийт зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь.

Хүснэгт №4

|                        | 1996 он | 1997 он | 1998 он | 1999 он | 2000 он |
|------------------------|---------|---------|---------|---------|---------|
| Зээлийн өрийн үлдэгдэл | 100%    | 100%    | 100%    | 100%    | 100%    |
| Чанаргүй зээл          | 49%     | 28%     | 38%     | 54%     | 27%     |

Нийт зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувийг харуулж буй хүснэгтээс харахад:


- энэ хувь тогтвортой буурахгүй, нэлээд хэлбэлзэлтэй байна. 1996, 1999 онуудад чанаргүй зээлийн эзлэх хувийн жин ихээр өссөн нь тухайн үеийн банкны систем дэхь гол гол банкуудын төлбөрийн чадварын хүндрэлтэй холбоотой.
- зарим банкуудыг татан буулгаж, өрийн үлдэгдлийг өр барагдуулах албанд шилжүүлэн, тэнцлийг сайжруулах арга хэмжээнүүд авагдаж байгаа үед чанаргүй зээлийн хувийн жин буурах хандлагатай болдог нь ажиглагдаж байна.

**Чанаргүй зээлийн бүтэц**

Хүснэгт №5

|                  | 1996 он | 1997 он | 1998 он | 1999 он | 2000 он |
|------------------|---------|---------|---------|---------|---------|
| Чанаргүй зээл    | 100%    | 100%    | 100%    | 100%    | 100%    |
| Хугацаа хэтэрсэн | 24%     | 31%     | 19%     | 7%      | 7%      |
| Хэвийн бус       | 11%     | 14%     | 15%     | 7%      | 8%      |
| Эргэлзээтэй      | 21%     | 22%     | 27%     | 11%     | 4%      |
| Муу              | 44%     | 32%     | 40%     | 75%     | 81%     |

**График 2.1.3. Чанаргүй зээлийн бүтэц**



Хүснэгт №5- аас харахад чанаргүй зээлд эзлэх муу зээлийн хувь тогтвортой өсч байгаа нь нэг талаас төлбөрийн чадвар нь хүндэрч татан буугдсан ХОТШ, Сэргээн босголт банкуудын өрийн үлдэгдэл шилжээгүй байгаатай холбоотой боловч нөгөө талаас өр нь банкны системийн зах зээлийн нөхцөлд зээл олгох, төлүүлэх үйл ажиллагаанд эрс өөрчлөлт хийх хэрэгтэй байгааг харуулж байна.